

“Хасэбэ-Интернэшнл” ХХК-д валют солих цэгийн үйл  
ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.3, Санхүүгийн зохицуулах хорооны 2007 оны 200 дугаар тогтоолоор баталсан “Валют солих цэгийн үйл ажиллагааны зохицуулалтын түр журам”-ын 5.4 дэх хэсэг болон “Хасэбэ-Интернэшнл” ХХК-ийн үүсгэн байгуулагчийн 2008 оны 14/08 дугаар тушаалыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1.“Хасэбэ-Интернэшнл” ХХК-д валют солих цэгийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгосугай.

2.Холбогдох хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ чанд биелүүлж ажиллахыг “Хасэбэ-Интернэшнл” ХХК /Ц.Батбаатар/ -д үүрэг болгосугай.

3.Тогтоолын биелэлтэд тогтмол хяналт тавьж ажиллахыг Бичил санхүүгийн газар /Н.Оюунчимэг/, олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар /Б.Мөнхжаргал/-т тус тус даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

Хуулбар үнэн:  
АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА

О.ГАНБАТ